


**ХЭРЭГЛЭГЧИЙН БУЮУ  
ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН АШИГЛАХ ТҮВШИН**  
**Хүсэлт илгээх хэсгийн заавар**



Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагч нь интернэтэд холбогдсон төхөөрөмжөөс веб хөтчүүдийн аль нэгийг ашиглан <https://psod.maf.gov.mn> домэйн хаягаар хандана.




Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагч нь анги, байгууллагын хүний нөөцөд өөрийн ашигладаг имэйл хаягаа бүртгүүлнэ.



Бүртгүүлсэн имэйл хаягаа “[Имэйл баталгаажуулах](#)” дээр дарж гарч ирсэн цонхны [Имэйл хаяг](#) нүдэнд бичин “[Имэйл баталгаажуулах холбоосыг илгээх](#)” товчийг дарснаар 6 оронтой код таны имэйл хаягт ирнэ.




Имэйл хаягт ирсэн 6 оронтой кодыг [“Имэйл баталгаажуулах холбоосыг илгээх”](#) товчийг дарснаар гарч ирэх цонхонд оруулж [Баталгаажуулах](#) товчийг дарна.




[Баталгаажуулах](#) товчийг дарснаар таны имэйл хаяг баталгаажиж тухайн системтэй ажиллах эрхтэй болно. Имэйл амжилттай баталгаажсаны дараа тухайн системд нэвтрэх өөрийн нууц үгийг заавал үүсгэнэ.


Баталгаажуулах товчийг дарснаар таны имэйл амжилттай баталгаажиж [Нууц үг тохируулах](#) товчийг дарснаар нууц үг шинэчлэх хэсэгт шилжинэ.




Өөрийн ашиглах нууц үгээ оруулаад [Шинэчлэх](#) товчийг дарснаар Энхийг сахиулах сонгон шалгаруулалтын системтэй ажиллах эрхтэй болно.



[Нэвтрэх хэсэг рүү шилжих](#) товчийг дарж нэвтрэх хэсэгт шилжинэ.



Нэвтрэх хэсэгт өөрийн баталгаажуулсан имэйл хаяг болон нууц үгээ оруулж **НЭВТРЭХ** товчийг дарснаар Бүртгэлийн үндсэн цонхонд шилжинэ.



ЭДЦХАХ

д/ч Батболор

ҮНДСЭН

ЗАРЛАЛ

ХЭРАГЛЭГЧ

д/ч Батболор

### Та Энхийг дэмжих ажиллагааны веб программд амжилттай нэвтрлээ.

Алхам 1. Та **ҮНДСЭН** цэсийн **Хүсэлт** илгээх туслах цэс дээр дарж Асуумж бөглөнө.

Алхам 2. Асуумжийг үнэн зөв бөглөсний дараа Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлт илгээнэ.

Алхам 3. ЭДА-нд үүрэг гүйцэтгэх хүсэлт илгээсний дараа **Бичиг баримтын бүрдэл** цэс дээр дарж бичиг баримтуудаа оруулна.

Алхам 4. Бүрдүүлэх ёстой бүх бичиг баримтаа оруулсан бол **Оролцооны байдал** туслах цэс дээр дарж оролцооны байдлаа харна.


Алхам 5. Та Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхтэй холбоотой санал, гомдолтой бол **Санал гомдол** туслах цэс дээр дарж илгээнэ.

Алхам 6. Та дараагийн жилүүдэд Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтэй бол **Хүсэлт илгээх он** туслах цэс дээр дарж хүсэлт илгээнэ.

**Санамж:** Асуумжийн мэдээллийг алдаатай илгээсэн тохиолдолд засах боломжгүй!

Эвсэгт хүчиний Программ хангамжийн төвд хөгжүүлэв © Бүх эрх хуулиар хангаалагдсан 2023

Гар утсан дээрээс бүртгэл хийж байгаа ЦАХ  
3 зураас бүхий товчин дээр дарж цэсийг  
дэлгэрэнгүй хэлбэрээр харна.



Хүсэлт илгээхийн тулд **YUNDSEN** цэсний **Хүсэлт илгээх** цэсийг дарснаар Танд асуумж бөглөх хэсэг гарч ирнэ. Асуумжийг үнэн зөв бөглөсний дараа илгээх товчийг дарна.

Асуумжийг үнэн зөв бөглөнө үү. /  
Дахин бөглөх боломжгүй бөгөөд  
тухайн асуумжийг ЗХЖШ-ын  
хүний нөөцийн хэлтэс шалгах тул  
худал бөглөсөн тохиолдолд таны  
гадаадад суралцах болон  
ажиллагаанд явах эрхийг 3  
жилээр хасахыг анхаарна уу!

Одоогийн албан тушаалд томилогдсон  
огноо

Ажиллагааны туршлагатай эсэх



БХ-ын болон бусад их, дээд сургууль,  
коллежийн өдрийн ангийн сургалт,  
дамжаанд сурч байгаа эсэх:

Төрийн албаны тухай хууль, цэргийн  
сахилгын дүрэмд заасан сахилгын  
шийтгэлтэй эсэх:

Тухайн асуумжийг Батлан хамгаалахын сайдын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/31 дугаар тушаалаар батлагдсан "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам"-ын 4.1; 4.2; 4.3.5; 4.3.6 дугаар заалтуудаар боловсруулсан.

Зөвхөн тухайн журамд заасан шаардлага хангасан цэргийн алба хаагчдад [Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтийн](#) цонх гарч ирнэ.

Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтийн цонхонд тухайн цэргийн албан хаагч өөрийн явахыг хүссэн ажиллагааны нэр, ээлжийг сонгоод [Хүсэлт илгээх](#) товчийг дарна. **“Амжилттай хүсэлт илгээлээ”** гэсэн мэдээлэл гарч ирснээр **Хүсэлт илгээх** хэсэг дуусна.




## Цэргийн алба хаагчийн баримт бичиг бүрдүүлэх заавар

Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтээ амжилттай илгээсэн цэргийн албан хаагчид өөрсдөө хариуцан баримт, бичгээ системд оруулна.

ҮНДСЭН цэсний Бичиг, баримтын бүрдэл цэсийг дарна.

1. Ажиллагааны нэр, ээлжийг сонгоно.
2. **+НЭМЭХ** товчийг дарна.
3. Бичиг, баримтын төрлөө сонгоод харгалзах PDF файлыг **Choose File** дээр дарж оруулна.
4. Нэмэх товчийг дарж хадгална.



### **Анхаарах !**

- ✓ Бүх шаардлагатай баримт, бичгийг төрөл тус бүрд нь PDF файл болгон нэг бүрчлэн оруулах шаардлагатай.
- ✓ Баримт бичгийг зөвхөн компьютероос оруулна. Гар утаснаас оруулах боломжгүй.
- ✓ Нэг PDF файлын хэмжээ 5mb – аас ихгүй байх шаардлагатай.
- ✓ ЗХЖШ-аас таны баримт бичгийг хянаад зөвшөөрсөн тохиолдолд тухайн баримт бичгийн ард **ЗӨВШӨӨРӨГДСӨН** гэсэн бичиг гарах ба тухайн баримт бичиг баталгаажна. Харин таны баримт, бичиг тухайн хүний нөөцийн хэлтсийн тавьсан шаардлагыг хангаагүй тохиолдолд **ТАТГАЛЗСАН** гэсэн бичиг яагаад татгалзсан тайлбарын хамт гарч ирэх бөгөөд та дахин засаж оруулах шаардлагатай.

Танд амжилт хүсье  
Холбоо барих утас: 3888,92113255